



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 23
№04 (1252)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

16.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	83
17.	Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай	85
18.	Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	87
19.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	93
20.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	94
21.	Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай	95

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

22.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 74	96
23.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 04	98
24.	Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай	Дугаар 05	99

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

25.	Монгол Улс болон Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)	100
-----	--	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.1.30 дахь заалт нэмсүгэй:

“5.1.30.“даатгагчийн баталгаа” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.13-т заасныг.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.8, 5.1.17 дахь заалтын “банкны баталгаа,” гэсний дараа “даатгагчийн баталгаа,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны болон даатгагчийн баталгаа, Засгийн газрын бондын хэлбэрээр, гадаадын хуулийн этгээд Монгол Улсын буюу гадаадын банкны баталгаа, Монгол Улсын буюу гадаадын даатгагчийн баталгаа, Монгол Улсын Засгийн газрын бонд, эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.”

2/43 дугаар зүйлийн 43.7 дахь хэсэг:

“43.7.Гүйцэтгэгч энэ хуулийн 43.6-д заасан үүргээ банкны баталгаа, даатгагчийн баталгаа, Засгийн газрын бондоор баталгаажуулж болох бөгөөд ийнхүү баталгаажуулсан тохиолдолд захиалагч барьцаалсан мөнгийг уг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр урьдчилан олгоно.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл. Даатгагчийн бусад үйл ажиллагаа

6¹.1. Даатгагч нь энэ хуулийн 4.1.1-д зааснаас гадна холбогдох этгээдээс бусад этгээдэд дараах даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно:

6¹.1.1. орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт;

6¹.1.2. хүн, хуулийн этгээд хоорондын ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах харилцаанд;

6¹.1.3. хуулиар хориглоогүй бусад харилцаанд.

6¹.2. Даатгагчийн баталгаа гаргахад Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасныг баримтална.

6¹.3. Энэ хуулийн 6¹.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт:

“4.1.13. “даатгагчийн баталгаа” гэж даатгагч нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь даатгагчид төлбөр төлөх үүргийг тус тус хүлээсэн хэлцлийг ойлгоно.”

3/14 дүгээр зүйлийн 14.2.22 дахь заалт:

“14.2.22. энэ хуулийн 6¹.1 дэх хэсэгт заасан даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, тайлбар нэмсүгэй:

1/59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийн тайлбар:

“Тайлбар: “Гадагш чиглэсэн” гэж иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн үр дагавар үүсгэсэн, тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжийг агуулаагүй байхыг ойлгоно.”

2/60 дугаар зүйлийн 60.3-60.6 дахь хэсэг:

“60.3. Захиргааны хэм хэмжээний актыг шинэчлэн батлах, эсхүл өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний актын дагуу эрх, үүрэг үүссэн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгаж болно.

60.4. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг буцаан хэрэглэхгүй.

60.5. Захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулахдаа тухайн захиргааны хэм хэмжээний актын анхдагч эх бичвэрт оруулна.

60.6. Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийг хүчингүй болгох, шинэчлэн найруулах, эрх олгосон заалтад агуулгын өөрчлөлт оруулах тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулна.”

3/64 дүгээр зүйлийн 64.6 дахь хэсэг:

“64.6. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг Засаг даргын хуульд заасан хориг тавих хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ.”

4/67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн тайлбар:

“Тайлбар: “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д 40 хүртэл хуудастай захиргааны хэм хэмжээний актыг бүрэн эхээр нь, 40-өөс дээш хуудастай захиргааны хэм хэмжээний актын тухайд захиргааны хэм

хэмжээний актыг баталсан шийдвэрийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан цахим холбоосын хамт нийтэлнэ. 40-өөс дээш хуудастай захиргааны хэм хэмжээний актыг баталсан захиргааны байгууллага хүсэлт гаргасан бол тухайн байгууллагын зардлаар “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтэлж болно.”

5/67 дугаар зүйлийн 67.7 дахь хэсэг:

“67.7.Энэ хуулийн 67.1-д заасан “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсэн болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулсан захиргааны хэм хэмжээний акт цаасан эх хувьтай адил байна. Нийтэлсэн хувь болон цахим хувь зөрвөл цаасан эх хувийг баримтална.”

2 дугаар зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтын “хуульд заасан” гэсний дараа “төрийн болон албаны” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Захиргааны байгууллага” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтын “шууд хүргүүлэх” гэсний дараа “, шаардлагатай тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулах” гэж, 33 дугаар зүйлийн 33.14 дэх хэсгийн “Захиргааны хэрэг” гэсний дараа “шүүхэд” гэж, 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалтын “хуулиар хориглоогүй” гэсний өмнө “хуулиар эрх олгосноос бусад тохиолдолд” гэж, 61 дүгээр зүйлийн 61.4.4 дэх заалтын “нийгмийн” гэсний дараа “харилцаанд” гэж, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн “Засгийн газраас” гэсний өмнө “Ерөнхийлөгч,” гэж, мөн зүйлийн 64.4 дэх хэсгийн “баталснаас хойш” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 66 дугаар зүйлийн 66.8 дахь хэсгийн “дүгнэлтийг үндэслэн” гэсний дараа “гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас баталсан” гэж, 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн “актын жагсаалтыг” гэсний дараа “ангилал, системчлэлтэйгээр” гэж, 98 дугаар зүйлийн 98.1.3 дахь заалтын “захиргааны байгууллагын” гэсний дараа “татгалзсан шийдвэр,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Захиргааны ерөнхий хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.Захиргааны байгууллагын үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.”

2/41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэг:

“41.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдээс шаардвал, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан

үүсвэл захиргааны байгууллага бичмэл бус хэлбэрээр гаргасан захиргааны актыг бичгээр баталгаажуулна.”

3/47 дугаар зүйлийн 47.1.6 дахь заалт:

“47.1.6.захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;”

4/67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг:

“67.2.Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн 67.1-д заасны дагуу нийтэлснээр хүчин төгөлдөр болно. Захиргааны хэм хэмжээний актад дагаж мөрдөх хугацааг өөрөөр зааж болно.”

4 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Хамтын удирдлагатай” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол хамтын удирдлагатай” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “11.1.1, 11.1.2-т” гэснийг “11.1-д” гэж, мөн хэсгийн “шийдвэртэй холбогдсон” гэснийг “шийдвэр гаргах” гэж, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “болгоно” гэснийг “болгож болно” гэж, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсгийн “журамд” гэснийг “бүлэгт” гэж, 61 дүгээр зүйлийн 61.5 дахь хэсгийн “амьдралд” гэснийг “харилцаанд” гэж, 64 дүгээр зүйлийн 64.3 дахь хэсгийн “Захиргааны хэм хэмжээний” гэснийг “Энэ хуулийн 64.2-т зааснаас бусад захиргааны хэм хэмжээний” гэж, 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийн “санг” гэснийг “сан, түүний ангилал, системчлэлийг” гэж, 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийн “гомдлыг” гэснийг “гомдлоо” гэж, 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, 103.3, 103.4 дэх хэсгийн “албан тушаалтнаар” гэснийг “этгээдээр” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.5 дахь заалтын “өөрөөр” гэснийг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсгийн “бүрэн эхээр нь” гэснийг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсгийн “Төрийн албаны тухай хуулийн 4.2.7,” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.4 дэх заалтыг, 62 дугаар зүйлийн 62.3.1 дэх заалтыг, 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүнээс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Бусад тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

Хүндэтгэсэн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

Зээлийн дугаар L0688A

МОНГОЛ УЛС

болон

АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК
хоорондын

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

(Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)

ОГНОО: 2022 оны 12-р сарын 5-ны өдөр



ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хэлэлцээрийг МОНГОЛ УЛС (цаашид “Зээлдэгч” гэх) болон АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК (цаашид “Банк” гэх) хооронд 2022 оны 12-р сарын 5-ны өдөр байгуулав.

Өмнөтгөл:

- A. Банк нь Зээлдэгчээс 2022 оны 08 сарын 17-ны өдөр 1-р хавсралтад туссан цочролуудын нөлөөг бууруулахад чиглэсэн Зээлдэгчийн Мөчлөг сөрсөн хөгжлийн зардлын хөтөлбөрийн зорилго, бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээг тусгасан хөгжлийн бодлогын асуудлаарх захидлыг хүлээн авсан.
- B. Зээлдэгч нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Банкнаас зээл авах хүсэлт гаргасан;
- C. Зээлдэгч нь Азийн хөгжлийн банк (“Хамтран санхүүжүүлэгч” гэх)-тай хамтран энэхүү Банкны зээлийн хэлэлцээрээс тусад нь хэлэлцээр (“Хамтран санхүүжүүлэх зээлийн хэлэлцээр” гэх)-ийг байгуулсан бөгөөд Хамтран санхүүжүүлэгч нь Зээлдэгчид нэг зуун сая (100,000,000) ам.доллартой тэнцэх зээл олгож, Хөтөлбөрийг хэсэгчлэн санхүүжүүлэхээр тохиролцсон;
- D. Ийнхүү дээр дурдсан хэлэлцээр байгуулсныг харгалзан Банк нь энэхүү Зээлийн хэлэлцээрээр доор дурсан хугацаа, нөхцөлийн дагуу Зээлдэгчид зээл олгохыг зөвшөөрөв.

Иймд, Банк болон Зээлдэгч дараах зүйлүүдийг харилцан тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; ТОДОРХОЙЛОЛТ

- 1.01. Ерөнхий нөхцөл (энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хавсралтад заасан) нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.
- 1.02. Энэхүү хэлэлцээрт том үсгээр бичсэн нэр томьёо нь тухайн хэсэгтээ агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол энэ нэр томьёог Ерөнхий нөхцөлд заасантай ижил утгаар хэрэглэнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. - ЗЭЭЛ

- 2.01. Банк нь Зээлийн хэлэлцээрийн 1-р хавсралтад заасан хөтөлбөрийг санхүүжүүлэхэд тусалцаа үзүүлэх зорилгоор энэхүү Зээлийн хэлэлцээрт зааж тусгасан хугацаа, нөхцөлийг болзлын дагуу нэг зуун сая (100,000,000) ам.долларын зээл (“Зээл” гэх) олгохоор үүгээр тохиролцов.
- 2.02. Зээлдэгч нь уг Зээлийн хэлэлцээрийн 2-р хавсралтын 3 дахь хэсэгт заасны дагуу Зээлийн хөрөнгийг зарцуулна.



- 2.03. Зээлдэгчийн төлөх урьдчилж төлөх шимтгэл нь зээлийн нийт дүнгийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна. Зээлдэгч нь уг шимтгэлийг Зээл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор төлнө.
- 2.04. Зээлдэгчийн төлөх хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл нь жилд Зээлийн ашиглаагүй үлдэгдлийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.
- 2.05. Зээлдэгчийн хүү төлөх хугацаа тус бүрд төлөх хүүгийн хувь нь Жишиг хүү дээр Хувьсах хүүг нэмсэн байдлаар төлнө. Эсхүл хүүгийн өөрчлөлт хийсэн тохиолдолд өөрчилсөн хүүгийн хувиар тооцоолно.
- 2.06. Зээлийн хүүг жил бүрийн 06 дугаар сарын 15-н болон 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд төлнө.
- 2.07. Зээлийн үндсэн дүнг энэхүү Зээлийн хэлэлцээрийн 3-р хавсралтад заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. - ХӨТӨЛБӨР

- 3.01. Зээлдэгч нь Хөтөлбөрийн зорилтыг хангахаар тууштай ажиллахаа үүгээр мэдэгдэж байна. Иймээс Зээлдэгч нь Сангийн ямаар дамжуулан, Ерөнхий нөхцөлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.02. Зээлийн хэлэлцээрийн 3.01 дэх заалтыг хязгаарлахгүйгээр, мөн Зээлдэгч ба Банк өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээрийн 2-р хавсралтад тусгасан заалтын дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 4.01. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 90 хоног дахь өдөр байна.

ТАВДУГААР ЗҮЙЛ. - ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ

- 5.01. Ерөнхий нөхцөлийн 10.02 дахь заалтын дагуу Сангийн сайд нь Зээлдэгчийн төлөөлөгч байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах хаягийг ашиглана:

Зээлдэгч:

Сангийн яам, Засгийн газрын 2-р байр,
С.Данзангийн гудамж 5/1,
Улаанбаатар хот - 15160, Монгол Улс
Факсын дугаар: +976-11- 320-247

5.03. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк:

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын
банкны төв байр, А цамхаг,
Азийн санхүүгийн төв № 1 Тяньченийн зүүн зам,
Чаоян дүүрэг, Бээжин хот - 100101, БНХАУ
Факсын дугаар: +86-10-8358-0002

Дээр заасан он, сар өдөр ДЭЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ гарын
үсэг зурав.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

[Эрх бүхий албан тушаалтан]

Нэр : _____

Албан тушаал: _____

**АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ**

[Эрх бүхий албан тушаалтан]

Нэр : _____

Албан тушаал : _____

1-Р ХАВСРАЛТ

Хөтөлбөрийн тодорхойлолт

Хөтөлбөрийн гол зорилго нь хүн амын, ялангуяа эмзэг бүлгийн нийгэм - эдийн засгийн цочролуудын даван туулах чадавхыг нэмэгдүүлэх юм. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд (а) өрхийн бэлэн мөнгөний эх үүсвэрийг богино хугацаанд шууд нэмэгдүүлэх; (б) эмзэг бүлгүүдэд, охид, эмэгтэйчүүдэд учирч буй нийгэм-эдийн засгийн нөлөөллийг багасгах; (в) инфляцыг бууруулж хүнсний аюулгүй байдлыг хангах. Бодлогын асуудлаарх захидалд Хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүй тусгасан болно.

2-Р ХАВСРАЛТ

Хөтөлбөрийн хэрэгжилт

I хэсэг. Хэрэгжүүлэх зохицуулалт

A. Холбогдох төрийн байгууллагын зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Сангийн ямаар дамжуулан Хөтөлбөрийн хэрэгжилт болон хяналт, тайлагналтыг хариуцна.

B. Бодлогын асуудлаарх яриа хэлэлцээ

1. Зээлдэгч Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгарсан аливаа асуудал, хязгаарлалтын талаар Банканд нэн даруй мэдэгдэх, мөн эдгээр асуудлыг шийдвэрлэх, зохицуулахад чиглэсэн зохих арга хэмжээг авахын тулд АХБ-тай идэвхтэй хамтран ажиллана.
2. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлж болох олон талт болон хоёр талт тусламжийн бусад агентлагуудтай бодлогын өөрчлөлт, хэлэлцүүлгийн талаар Банканд мэдээлж байх бөгөөд Банкинд аливаа бодлогын яриа хэлэлцээрийн талаар санал өгөх боломжийг олгоно. Зээлдэгч бодлогын яриа хэлцлийг эцэслэн боловсруулж хэрэгжүүлэхийн өмнө Банкны саналыг харгалзан үзнэ.

B. Монголын талын санхүүжүүлэлтийг ашиглах

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийн зорилгод нийцсэн тодорхой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг санхүүжүүлэхэд Монголын талын санхүүжүүлэлтийн хөрөнгийг зарцуулна.

Г. Хориглосон үйл ажиллагаа

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн боловсон хүчин болон бусад төлөөлөгчдийг Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ёс зүйн дээд хэм хэмжээг баримтлахыг шаардана. Үүний тулд Зээлдэгч нь (а) хүн болгон нь зээлтэй холбоотой аливаа хориотой үйл ажиллагаа явуулахгүй байх; (б) Хориглосон үйлдлийн талаарх бодлогын дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг баталгаажуулна.

Д. Байгаль орчны болон нийгмийн шаардлага

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хамтран санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкны “Хамгааллын бодлого”-ын дагуу хэрэгжүүлнэ.
2. Дээрх 1 дэх заалтыг хязгаарлахгүйгээр Хамтран санхүүжүүлэгчийн “Хамгааллын бодлого”-ын дагаж мөрдөж буй тухай гомдол Банканд ирсэн тохиолдолд Банк уг гомдлыг Хамтран санхүүжүүлэгчид шалгуулахаар шилжүүлж, тэр нь өөрийн хариуцлагын шат дамжлагаар мөрдөн шалгана гэдгийг Зээлдэгч хүлээн зөвшөөрч байна.

II хэсэг. Хяналт, үнэлэлт болон тайлан

А. Хөтөлбөрийн хяналт, тайлан

1. Зээлдэгч нь (а) үндсэн оролцогч талуудтай бодлогын яриа хэлэлцээ хийх, хэлэлцээний үр дүнг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой платформыг Мөчлөг сөрсөн санхүүжилтийн зардлын хөтөлбөрийн хүрээнд багтаан боловсруулна; ба (б) үүнийг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарч байгаа бол хариу арга хэмжээ авна.
2. Зээлдэгч (а) өөрийн хяналт, шалгалтын механизмын дагуу хяналт тавьж, үнэлж, улирал тутам тайланг Банканд гаргаж өгнө; (б) хяналт, шалгалтыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв болон хүний нөөцийг бүрдүүлнэ.

Б. Санхүүгийн тайлан, аудит

1. Зээлдэгч нь Банкны хүлээн зөвшөөрөх хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу Хадгаламжийн данстай байж, тусад нь данс, бүртгэлийг хөтөлнө.



2. Банкны хүсэлтээр Зээлдэгч Хадгаламжийн дансны санхүүгийн тайланд аудит хийлгэх ба аудиторын хараат бус байдал, мэргэшил, туршлага, ажлын хүрээ зэрэг нь Банкаар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартад нийцсэн, эсвэл Банкаар зөвшөөрөгдсөн дотоод стандартад нийцсэн байх. Бэлтгэл ажил хангагдсаны дараа нэн даруй, гэхдээ Банк хүсэлт гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн хуулбар болон санхүүгийн тайлангийн талаарх аудиторуудын дүгнэлтийг англи хэл дээр Банканд ирүүлнэ.

III хэсэг. Зээлийн ашиглалт

A. Ерөнхий нөхцөл

1. Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II зүйл, энэ заалт болон Банкнаас Зээлдэгчид мэдэгдэх нэмэлт зааварчилгааны дагуу зээлийн хөрөнгөө татан авч болно.
2. *Зээлийн хуваарилалт.* Зээлийг нэг удаагийн санхүүжилтээр хуваарилах бөгөөд Зээлдэгч Зээлийн данснаас мөнгө гарган авах боломжтой. Энэ зорилгоор Зээлийн дүнгийн хуваарилалтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Ашиглалт	Ашиглалтын дүн (ам.доллаароор)
Ашиглалт	100,000,000
НИЙТ ДҮН	100,000,000

B. Ашиглалтын нөхцөл, хугацаа

1. *Ашиглалтын нөхцөл.* Энэ хэсгийн А заалтад өөрөөр заасан ч Банк урьдчилж төлөх шимтгэлийг бүрэн хүлээн авч, Хамтарсан санхүүжилтийн гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл Зээлийн данснаас мөнгө гаргахгүй.
2. *Зээлийн мөнгөн дүнгийн хадгаламж.* Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд:

(а) Зээлийн данснаас гарсан бүх мөнгийг Банк Зээлдэгчийн заасан дансанд байршуулна (“Хадгаламжийн данс”);

(б) Зээлдэгч нь Зээлийн мөнгөн дүнг Хадгаламжийн дансанд оруулах бүрд түүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Зээлдэгчийн төсвийн удирдлагын тогтолцоонд бүртгэхийг баталгаажуулна.



3. *Үл зөвшөөрөх жагсаалт.* Энэхүү 2-р хавсралтын 1 дэх хавсралтад заасан аливаа зүйлийг санхүүжүүлэхэд Зээлийн орлогыг татан авахгүй.
4. *Ашиглалтын хугацаа.* Хаалтын хугацаа нь 2023 оны 06-р сарын 30-ны өдөр байна.

IV хэсэг. Бусад

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Зээлийн орлогоос гадна шаардагдах хөрөнгө, барилга байгууламж, үйлчилгээ болон бусад эх үүсвэрийг шаардлагатай бол нэн даруй гаргана.

2-р хавсралтын 1 дэх хавсралт

Үл зөвшөөрөх жагсаалт

Дараах зүйлсийн санхүүжилтэд Зээлийг зарцуулахгүй:

- i. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны ангилал, түүний 3-р хувилбар (SITC, Rev 3)-т багтсан дараах бараа, бүтээгдэхүүн, мөн Олон Улсын Худалдааны Ангилалд шинээр нэмэгдэх барааны дэд бүлэг, бүтээгдэхүүнийг хориглоно хэмээн Банкнаас Зээлдэгчид үүгээр мэдэгдэв:

Хүснэгт: Шаардлага хангахгүй зүйлс

Бүлэг	Гарчиг	Эд зүйлсийн тодорхойлолт
112		Согтууруулах ундаа
121		Тамхи, боловсруулаагүй; тамхины хаягдал
122		Боловсруулсан тамхи (тамхи орлуулагч агуулсан эсэхээс үл хамааран).
525		Цацраг идэвхт бодис болон холбогдох материал
667		Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, боловсруулаагүй эсвэл боловсруулсан
718	718.7	Цөмийн реактор ба тэдгээрийн эд анги, цөмийн реакторт цацраггүй түлшний элементүүд (хайрцаг)
728	728.43	Тамхи боловсруулах машин
897	897.3	Алт, мөнгө, цагаан алтны бүлгийн металаар хийсэн үнэт эдлэл (бугуйн цаг, цагны хайрцаг) болон алт дархны болон мөнгөний дархны эдлэлүүд (түүний дотор эрдэнийн чулуу орно)
971		Алт (мөнгөн бус) (алтны хүдэр, баяжмал үүнд орохгүй)



Эх сурвалж: Нэгдсэн Үндэстний Байгууллагын стандарт: олон улсын худалдааны ангилал, 3 дахь нэмэлт өөрчлөлт.

- ii. Зээлдэгчийн мөнгөн тэмдэгтээр хийгдсэн дотоодын зарлага;
- iii. дотоодын болон олон улсын санхүүгийн байгууллага, агентлаг санхүүжүүлэхээр тохирсон, эсхүл санхүүжүүлсэн бараа, бүтээгдэхүүний зардал, үүнд мөн Банкны зээл, тусламжийн санхүүжилт хамаарагдана;
- iv. цэргийн болон хагас цэрэгжүүлсэн бараа бүтээгдэхүүн болон тансаг хэрэглээ;
- v. хар тамхи;
- vi. байгаль орчинд аюултай бараа, түүнийг үйлдвэрлэх, ашиглах, эсвэл Зээлдэгчийн хууль тогтоомж болон зээлдэгчийн нэгдсэн олон улсын гэрээний дагуу импортлохыг хориглосон бараа бүтээгдэхүүн;
- vii. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн VII бүлэг, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийн дагуу Зээлдэгчээс хориглосон аливаа төлбөрийн дансны зардал.

3-Р ХАВСРАЛТ

Эргэн төлөлтийн хуваарь

1. Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн дүнг төлөх огноо, үндсэн дүнг төлөх өдөр тус бүрд төлөх зээлийн нийт дүнгийн хувийг (“Хугацаа” гэх) харуулав. Хэрэв төлөх эхний өдрийн байдлаар зээлийн үндсэн дүнг бүрэн татан авсан байгаа бол үндсэн дүнг төлөх өдөр бүрд Зээлдэгчийн төлөх зээлийн үндсэн дүнг Банк дараах байдлаар үржүүлэх замаар тодорхойлно: (а) татан авсан Зээлийн үлдэгдэл, үндсэн дүнг төлөх эхний өдрийн байдлаар; (б) Үндсэн дүнг төлөх огноо тус бүрд ногдох хэсэгчилсэн хувь.

Эргэн төлөлтийн хуваарь	Хэсэгчилсэн хувь (хувиар)
Жил бүрийн 06 дугаар сарын 15-н болон 12 дугаар сарын 15-н, 2025 оны 12 дугаар сарын 15-наас эхлэн 2029 оны 06 дугаар сарын 15-н хүртэл	12.5%

2. Зээлийн үндсэн дүнг төлөх эхний өдрийн байдлаар Зээлийг бүрэн татан аваагүй бол Зээлдэгчийн үндсэн дүнг төлөх өдөр бүрд төлөх зээлийн үндсэн дүнг дараах байдлаар тодорхойлно:
 - (а). Үндсэн дүнг төлөх эхний өдрийн байдлаар зээлийг тодорхой хэмжээгээр татан авсан тохиолдолд Зээлдэгч нь энэхүү хавсралтын 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн өдрийн байдлаар авсан зээлийн үлдэгдлийг эргүүлэн төлнө.

- (б) Үндсэн дүнг төлсөн эхний өдрөөс хойш татан авсан аливаа дүнг Банкнаас тодорхойлсон хэмжээгээр үндсэн дүнг төлөх өдөр бүр төлж барагдуулна, ингэхдээ татан авсан дүн болгоныг бутархайгаар үржүүлнэ, бутархайн хүртвэр нь энэхүү хавсралтын 1 дэх заалтад буй хүснэгтэд заасан үндсэн дүнг төлөх тухайн огноонд ногдох хэсэгчилсэн хувь байна (“анхдагч хэсэгчилсэн хувь” гэх), бутархайн хуваагч нь тухайн өдөр буюу түүнээс хойших үндсэн дүнг төлөх огноонд ногдох үлдсэн бүх анхдагч хэсэгчилсэн хувийн нийлбэр байна.
3. (а) Зөвхөн үндсэн дүнг тооцох зорилгоор аливаа Үндсэн дүнг төлөх өдрөөс өмнө хуанлийн хоёр (2) сарын дотор татан авсан зээлийн дүнг татан авсан бөгөөд тухайн татан авалтын дараах хоёр дахь Үндсэн дүнг төлөх өдрийн өмнө төлөгдөөгүй байгаа гэж үзнэ. Тухайн дүнг татан авалтын дараах хоёр дахь Үндсэн дүнг төлөх өдрөөс эхлэн Үндсэн төлбөрийг төлсөн өдөр болгон төлнө.
- (б) Энэ зүйлийн (а) дэд заалтад заасан байгаа ч, хэрэв Банк ямар ч үед үндсэн төлбөрийг төлөх өдөр буюу түүнээс хойших хугацаанд нэхэмжлэл гаргадаг төлбөрийн системийг нэвтрүүлсэн бол уг дэд хэсгийн заалтууд ийм тооцооны системийг баталсны дараа хийсэн аливаа татан авалтад цаашид хамаарахгүй.

ХАВСРАЛТ

I хэсэг. Нэр томъёоны тодорхойлолт

1. “Зээлдэгч” гэж ерөнхий нөхцөлд тодорхойлсон нэр томъёог хүлээн авагчийг хэлнэ.
2. “Монголын талын санхүүжилт” гэж Хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн хөрөнгөөс бүрдүүлсэн үндэсний мөнгөн тэмдэгтийг.
3. “Хамтран санхүүжүүлэгчийн ХБ” гэж Хамтран санхүүжүүлэгчийн “Хамгааллын бодлого”-ыг (2009) хэлнэ.
4. “Хамтран санхүүжүүлэх” гэж Ерөнхий нөхцөлийн хавсралтын 10 дахь хэсэгт заасан зорилгоор Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд туслах зорилгоор Хамтран санхүүжүүлэгчээс олгох нийт нэг зуун сая долларыг хэлнэ.
5. “Хамтран санхүүжүүлэх гэрээ” гэж Зээлдэгч болон Хамтран санхүүжүүлэгчийн хооронд байгуулсан хамтын



- санхүүжилтийн нийлбэр дүнгээр Хамтран санхүүжүүлэгчийн энгийн хөрөнгийн эх үүсвэрээс зээл олгохыг хэлнэ.
6. “Хадгаламжийн данс” гэж 2-р хавсралтын III.В.3-т заасны дагуу Зээлийн данснаас мөнгө байршуулах Зээлдэгчээс тогтоосон, Банктай тохиролцсон хадгаламжийн дансыг хэлнэ.
 7. “Ерөнхий нөхцөл” гэж 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Төрийн баталгаат зээлийн ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
 8. “Бодлогын талаарх захидал” гэж Зээлийн гэрээний заалт (А)-д дурдсан хөгжлийн бодлогын захидлыг хэлнэ.
 9. “Хориотой үйлдлүүд” гэж “Хориотой үйлийн талаар баримтлах бодлого”-д туссан үйл ажиллагааг хэлнэ.
 10. “Хориотой үйлдлүүдийн талаар баримтлах бодлого” гэж Банкны 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн “Хориотой үйлийн талаар баримтлах бодлого”-ыг хэлнэ.

II хэсэг. Ерөнхий нөхцөлийн өөрчлөлт

Ерөнхий нөхцөлийн өөрчлөлтүүд нь дараах байдалтай байна:

1. Ерөнхий нөхцөлд “Төсөл” гэсэн нэр томъёо ашигласан тохиолдолд “Хөтөлбөр” гэсэн нэр томъёогоор солино.
2. 5.01-р хэсэг. Төслийн гүйцэтгэлийг өөрчлөв. “5.01-р хэсэг. Програмын гүйцэтгэл. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд: (i) зохих нягт нямбай, үр ашигтай, засаг захиргаа, санхүү, төрийн бодлого, нийгэм, засаглалын зөв практикт нийцүүлэн хэрэгжүүлэх; (ii) Хууль зүйн гэрээний заалтын дагуу.”
3. 5.09-р хэсэг. Санхүүгийн удирдлага; Санхүүгийн тайлан; Аудитууд гэснийг хассан.



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003

